



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/63

Улаанбаатар хот

Засаг даргын дэргэдэх "Өсвөрийн шигшээ баг"-ийн нэрэмжит "Волейбол"-ын нээлттэй тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилтот жил"-ийн хүрээнд дүүргийн Засаг даргын дэргэдэх "Өсвөрийн шигшээ баг"-ийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор "Волейбол"-ын тэмцээнийг 2024 оны 04 дүгээр 13, 14-ний өдрүүдэд зохион байгуулахыг Биеийн тамир, спортын хороо (Г.Тэмүүлэн)-нд даалгасугай.

2. Тэмцээн зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, шаардагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээн зохион байгуулахад шаардлагатай 1,160,000 (Нэг сая нэг зуун жаран мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т, санхүүгийн тайланг 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн дотор Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг Биеийн тамир, спортын хороо (Г.Тэмүүлэн)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL\2024 он ажил\захирамж

11232

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 04 сарын 09-ны өдрийн 163 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт



УДИРДАМЖ

2024 оны 04 дүгээр сарын 09

Багахангай дүүрэг

Засаг даргын дэргэдэх “Өсвөрийн шигшээ баг”-ийн нэрэмжит  
“Волейбол”-ын тэмцээн зохион байгуулах тухай

**НЭГ.ЗОРИЛГО**

“Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилтот жил”-ийн хүрээнд дүүргийн Засаг даргын дэргэдэх “Өсвөрийн шигшээ баг”-ийг иргэдэд таниулах, сурталчлах, хөгжүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах, харилцан туршлага судлах, хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд тэмцээний зорилго оршино.

**ХОЁР.ТЕХНИКИЙН ЗӨВЛӨГӨӨН**

Тэмцээний техникийн зөвлөгөөнийг 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 14:00 цагт Биеийн тамир спортын хороонд зохион байгуулна. Техникийн зөвлөгөөнөөр тэмцээн явагдах дүрмийг танилцуулна. Тэмцээнд оролцох багийн ахлагч мэдүүлэгтэйгээ цагтаа ирнэ. Мэдүүлэг стандартын шаардлага хангасан байх. Мэдүүлэгт ороогүй тамирчин оролцох боломжгүй.

Жич: Шаардлага хангаагүй мэдүүлэг авахгүй болно.

Мэдүүлгийн загвар

Батлав

№	Овог нэр	Нас	Хүйс	Тоглогчийн үүрэг	Утасны дугаар	Эрүүл мэнд
1						

Мэдүүлэг гаргасан:.....

Эмчийн гарын үсэг.....тамгатай байх

**ГУРАВ.ТЭМЦЭЭН ЯВАГДАХ ХУГАЦАА**

Тэмцээн 2024 оны 04 дүгээр сарын 13, 14-ний өдрүүдэд зохион байгуулагдана.  
Тэмцээн 2024 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр 08:30 цагт эхэлнэ.

**ДӨРӨВ.САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ**

Багууд эрхийн хураамж болох 120,000 (Нэг зуун хорин мянга) төгрөгийг Хаан банк 5754088867 (Биеийн тамир, спортын хорооны Нярав) М.Цэцэгбадам дансанд шилжүүлж бүртгэл баталгаажна.

## **ТАВ.ОРОЛЦОХ БАГУУД**

Тэмцээнд Багахангай дүүргийн иргэд, Өсвөрийн шигшээ багийн тамирчид, Налайх, Багануур, Төв аймаг болон Багахангай дүүргийн ойролцоох сумдын баг тамирчид нээлттэй оролцоно.

Тэмцээний насны ангилал: 16 наснаас дээш

### **ЗУРГАА.ТЭМЦЭЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА:**

- ✓ Тамирчид жигд хувцастай байх
- ✓ Гадны пүүзээ сольж талбай дээр гарах
- ✓ Шүүгчидтэй маргалдахыг хатуу хориглоно
- ✓ Баг 8 хүний бүрэлдэхүүнтэй байна
- ✓ Тэмцээнд эрэгтэй, эмэгтэй баг тамирчид оролцоно
- ✓ Тэмцээн цагийн хуваарийн дагуу явагдах тул 5 минут хүлээгээд ирэхгүй багийн хожлыг эсрэг багт өгнө.

### **ДОЛОО.ШАГНАЛ УРАМШУУЛАЛ**

**Тэргүүн байр** (Эрэгтэй, эмэгтэй)-Алтан медаль, Өргөмжлөл, Мөнгөн шагнал

**Дэд байр** (Эрэгтэй, эмэгтэй)-Мөнгөн медаль, Өргөмжлөл, Мөнгөн шагнал

**Гутгаар байр** (Эрэгтэй, эмэгтэй)-Хүрэл медаль, Өргөмжлөл, Мөнгөн шагнал

**Шилдэг довтлогч** (Эрэгтэй, эмэгтэй)-Цом, Мөнгөн шагнал

**Шилдэг холбогч** (Эрэгтэй, эмэгтэй)-Цом, Мөнгөн шагнал

**ХОЛБОО БАРИХ ДУГААР: 88028120**

### **ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:**

**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРОО  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ӨСВӨРИЙН ШИГШЭЭ БАГ**

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 09 сарын 11-ны өдрийн 1/13 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт



“ӨСВӨРИЙН ШИГШЭЭ БАГ”-ИЙН НЭРЭМЖИТ  
“ВОЛЕЙБОЛ”-ЫН ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	1-р байр Алтан медаль	ш	16	15,000	240,000
2	2-р байр Мөнгөн медаль	ш	16	15,000	240,000
3	3-р байр Хүрэл медаль	ш	16	15,000	240,000
4	Өргөмжлөл	ш	6	20,000	120,000
5	Шилдэг холбогч цом	ш	2	35,000	70,000
6	Шилдэг довтлогч цом	ш	2	35,000	70,000
7	Хулдаасан хэвлэл	M2	12	15,000	180,000
<b>Нийт</b>					<b>1,160,000</b>